



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ГУРАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 27/17

Бор-Өндөр

Наранхүү овогтой Золзаяад жирэмсэний
болон амаржсаны амралт олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3 дэх заалт, 137 дүгээр зүйлийн 137.1 дэх заалт зэргийн үндэслэн ТУШААХ нь:

1. Багшийн туслах Н. Золзаяагийн жирэмсэний болон амаржсаны амралтыг 2023 оны 09 дугаар сарын 29 -ны өдрөөс эхлэн олгосугай.

2. Багшийн туслах Н. Золзаяад хариуцаж байсан тоног төхөөрөмж, эд хөрөнгө, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичиг, бусад эд зүйл, тойрох хуудас зуруулан ажлыг багшийн туслах Б. Хуланд хүлээлцүүлэхийг нярав Л. Отгончимэг, тооллогын комиссын дарга Т. Эрдэнэчимэг нарт үүрэг болгосугай.

3. Туслах багш жирэмсэний болон амаржсаны амралтын мөнгийг зохих хувиар бодож олгохыг нягтлан бодогч М. Саруултуяад зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ  Д. БӨРЭЛМАА



D:Ajil Tushaal A-4

238509117



ХЭНГИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ГУРАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 5/161

Бор-Өндөр

Дэмбэрэл овогтой Отгонцэцэг
тогоочоор авч ажиллуулах тухай.

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33.3.1, 33.3.2, дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.1.1, 43.1.2 дахь заалт, 64 дугаар зүйлийн 64.1, 101 дүгээр зүйлийн 101.1 дахь заалт, 120 дугаар зүйлийн 120.4, 120.5 дахь заалт, 131 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Дэмбэрэл овогтой Отгонцэцэгийг 2023 оны 11 сарын 29 -ны өдрөөс тогоочоор түр ажиллуулсугай.

2. Тогоочоор ажиллах хугацаанд хуулинд заасан эрх үүргээ биелүүлж холбогдох дүрэм журмыг чанд мөрдөж, албан тушаалын тодорхойлолтын дагуу ажил үүргээ чанартай хийж гүйцэтгэхийг нярав Б. Биндэръяа нь гүйцэтгэх ажлын чиг үүрэгт хяналт тавьж зөвлөн туслаж ажиллахыг дотоод хяналтын ажилтан биеийн тамирын багш (Г. Сүрэн)-д үүрэг болгосугай.

3. Д. Отгонцэцэг нь ТҮ-4 сүлжээний үндсэн цалин 827.000 / найман зуун жаран найман мянга/ төгрөгөөр цалинжуулж, ажилласан хугацааны цалин, нэмэгдлийг зохих ёсоор бодож олгохыг нягтлан бодогч (М. Саруултуяа)-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ  Д. ГЭРЭЛМАА

239509190



ХЭНГИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ГУРАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 7/166

Бор-Өндөр

Чулуунболд овогтой Отгонзулийг багшийн
туслахаар ажилуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, дахь заалт, дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.4 дахь заалт, 101, дүгээр зүйлийн 101.1 дахь заалт, Монгол улсын боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чулуунболд овогтой Отгонзул нь 2023 оны 12 сарын 15 ны өдрөөс эхлэн багшийн туслахаар ажилуулсугай.
2. Багшийн туслах Ч.Отгонзулын цалинг ТҮБД-1-ээр тогтоон 1.100.000 төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч М. Саруултуяа зөвшөөрсүгэй.
3. Багшийн туслах Ч. Отгонзул нь багшийн туслахын албан тушаалын тодорхойлолт, цэцэрлэг дээр мөрдөгддөг дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.
4. Багшийн туслах Ч. Отгонзул нь багшийн туслахаар бүлэг дээр ажиллах хугацаандаа ангийн ариун цэвэр, халдвар хамгаалалт цэвэрлэгээ үйлчилгээ дээр хяналт тавьж зөвлөн ажиллахыг эмч О. Наранцацралд үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ  Д.ГЭРЭЛМАА



D: Ajil Tushaal A